



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАГАНУУР ТӨХК-ИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2023/58/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх  
аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: Я.Самбууням  
Утас: 260949 Цахим хаяг: sambuunyamyа@audit.gov.mn  
Аудитор: Т.Мягмаржав  
Утас: 260512 Цахим хаяг: myagmarjavt@audit.gov.mn  
Гэрээгээр гүйцэтгэсэн Нийслэл аудит ХХК-ийн захирал:  
Т.Сугарсүрэн  
Утас: 7011-0095 Цахим хаяг: info@niislelaudit.mn

Улаанбаатар хот  
2023 он



**АГУУЛГА**

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.1 Компани, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Компанийн гадаад, дотоод орчин .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт .....	13
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл .....	16
4. Аудитын тайлан .....	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	19
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	20
4.5.1 Завсрын аудитын талаар.....	20
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	21
5. Аудитын илрүүлэлт.....	21
5.1 Төлбөрийн акт .....	22
5.2 Албан шаардлага.....	22
5.2 Зөвлөмж.....	24
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	25

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДЦС	Дулааны цахилгааны станц
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБӨНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Баянголзуур 3, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04 37, Факс: 51-26-42 30  
E-mail: info@audit.gov.mn

БАГАНУУР ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ  
Д.ТҮВШИНЖАРГАЛ ТАНАА

2023.03.15 № 07/СҮЗ  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Багануур ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тус компанийн тайлант хугацааны эцэст дансаар байвал зохих 3,234.8 сая төгрөгийн харилцагч байгууллагуудаас авах авлагын үлдэгдлийн дүнгийн талаар аудитын хангалттай ба зохистой нотолгоо авч чадаагүй. Иймээс бид уг дүнд ямар нэгэн залруулга хийх шаардлагатай эсэхийг тогтоох боломжгүй болсон.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй дараах алдаа, зөрчил нь тогтоосон 1,509.1 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд: Авлагын 3,234.8 сая, өглөгийн 9,407.3 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж 72.8 сая төгрөгийг зарцуулсан, ТБОНӨХБАУХА тухай хуулийг зөрчиж 10,820.3 сая төгрөгийн шууд гэрээ байгуулж, худалдан авалтыг хийсэн.

### Асуудлыг онцолсон хэсэг

Багануур ТӨХК нь Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон тайлант оноос хэрэгжиж эхэлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу Хамтын гэрээнд тайлант хугацаанд өөрчлөлт оруулаагүй байна. Тус компани ТӨБЗГ-ын 2022 оны 64 дүгээр тогтоолын дагуу хийгдсэн ТӨБЗГ-аас зохион байгуулагдсан үндсэн хөрөнгийн улсын тооллогод хамрагдсан байна.



2022-2023 оны өвлийн ачааллыг хүндрэлгүй даван туулах, ирэх оны үйл ажиллагааг дэмжих зорилгоор 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Эрдэнэс таван толгой ХХК-тай 23,900.0 сая төгрөгийн зээлийн гэрээг байгуулж, тайлант онд 9,270.0 сая төгрөгийг хүлээн авсан.

Мөн түүнчлэн Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 588 дугаар тогтоолоор Эрчим хүчний зориулалтаар борлуулж буй 1 тонн нүүрсний үнийг нэмэгдүүлсэн ч энэ нь уурхайн хэвийн үйл ажиллагааг бүрэн ханган ажиллахад хангалттай дэмжлэг болж чадахгүй тул уг асуудлыг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн дээд байгууллагууд бодлогын хэмжээнд нэн яаралтай шийдвэрлэх шаардлагатай байна.

#### **Аудитын гол асуудал**

Багануур ТӨХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан бөгөөд нийт орлогыг 156,917.1 сая төгрөг, нийт зардлыг 197,641.1 сая төгрөг, 40,724 сая төгрөгийн цэвэр алдагдалтай ажиллахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 162,787.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 196,446.7 сая төгрөгийн зардал гарган, 33,659.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Багануур ТӨХК нь 2022 онд техник шинэчлэл, хөрөнгө оруулалтын чиглэлээр 9 багц арга хэмжээнд 16,842.6 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 13,824.1 сая төгрөгийн техникийн шинэчлэл, хөрөнгө оруулалтыг хийжээ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 82.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*В. М.* Ц.НАРАНЧИМЭГ



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,050,042,808.71	3,982,323,532.05
1.1.2	Дансны авлага	8,775,365,449.82	10,010,013,641.16
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	371,175,156.89	739,531,557.44
1.1.4	Бусад авлага	64,240,000.00	74,240,000.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	32,943,858,583.54	45,001,906,854.70
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	9,323,479,731.94	10,839,246,771.63
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>52,528,161,730.90</b>	<b>70,647,262,356.98</b>
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	176,950,745,513.87	151,858,946,967.51
1.2.2	Биет бус хөрөнгө	4,533,635,405.80	4,358,225,684.60
1.2.3	Уул уурхайн хөрөнгө/УУ хөгжүүлэлт, хөрс хуулалт/	27,750,619,346.40	27,209,712,833.10
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	999,767,331.34	999,767,331.34
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	764,393,387.00	764,393,387.00
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>210,999,160,984.41</b>	<b>185,191,046,203.55</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>263,527,322,715.31</b>	<b>255,838,308,560.53</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	41,551,861,528.33	52,405,529,509.13
2.1.1.2	Цалингийн өглөг	1,727,755,453.45	2,521,958,781.00
2.1.1.3	Татварын өр	36,418,069,735.09	48,087,404,572.38
2.1.1.4	НДШ - ийн өглөг	10,908,935,599.82	12,179,131,636.82
2.1.1.5	Богино хугацаат зээл	44,886,133,192.80	46,716,839,284.27
2.1.1.6	Хүүний өглөг	1,738,799,203.90	2,579,831,249.31
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	12,971,933.50	12,968,712.50
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	2,108,794,026.25	431,594,370.84
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>139,353,320,673.14</b>	<b>164,935,258,116.25</b>
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	43,410,466,942.54	47,395,869,334.18
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	1,167,266,443.09
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	2,203,678,000.00	8,103,541,421.55
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>45,614,144,942.54</b>	<b>56,666,677,198.82</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>184,967,465,615.68</b>	<b>221,601,935,315.07</b>
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	1,573,077,000.00	1,573,077,000.00
2.3.2	хувийн	524,359,000.00	524,359,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	60,685,388,076.98	60,685,388,076.98
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	7,294,912,713.63	(28,546,450,831.52)
2.3.10	Тусгай зориулалтын нөөцийн сан	8,482,120,309.02	-
2.3.11	Эздийн өмчийн дүн	78,559,857,099.63	34,236,373,245.46
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>263,527,322,715.31</b>	<b>255,838,308,560.53</b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 он	2022 он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	152,292,931,653.25	160,262,944,907.11
2	Борлуулалтын өртөг	130,809,451,818.36	163,002,692,433.64
3	Нийт ашиг(алдагдал)	21,483,479,834.89	(2,739,747,526.54)
4	Түрээсийн орлого	17,478,212.26	20,563,400.00
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	4,164,713.64	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	356,523,350.84	782,792,383.66
9	Борлуулалт, маркетингийн зардал	669,139,400.01	567,136,179.19
10	Ерөнхий ба удирдлагын зардал	10,203,846,720.57	21,506,033,983.12
11	Санхүүгийн зардал	1,903,579,779.87	3,065,094,742.48
12	Бусад зардал	7,325,084,154.34	5,600,353,774.58
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	1,121,016,336.81	(984,174,801.56)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	164.48	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,881,012,558.13	(33,659,185,223.81)
19	Орлогын татварын зардал	1,370,853,622.56	25,020,000.01
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,510,158,935.57	(33,684,205,223.82)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,510,158,935.57	(33,684,205,223.82)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	1,510,158,935.57	(33,684,205,223.82)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-




Багануур ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Тусгай зориулалтын нөөцийн сан	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	9,657,130,648.58	7,672,308,688.50	80,112,263,414.06
НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(1,175,010,339.54)	(1,887,554,910.44)	(3,062,565,249.98)
Залруулсан үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	8,482,120,309.04	5,784,753,778.06	77,049,698,164.08
Өмчит гарсан өөрчлөлт					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				1,510,158,935.57	1,510,158,935.57
Зарласан ногдол ашиг					-
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	8,482,120,309.04	7,294,912,713.63	78,559,857,099.63
НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(8,482,120,309.02)	-	(8,482,120,309.02)
Залруулсан үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	-	7,294,912,713.63	70,077,736,790.61
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(33,684,205,223.82)	(33,684,205,223.82)
Зарласан ногдол ашиг				-	-
Өмчид гарсан өөрчлөлт				(2,157,158,321.33)	(2,157,158,321.33)
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	-	(28,546,450,831.52)	34,236,373,245.46

СНАГ-2023/58/НА-СТА-ТӨА





## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>151,077,689,218.70</b>	<b>161,237,556,096.93</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	150,672,159,365.77	160,957,619,734.73
	Буцаан авсан албан татвар	360,314,075.12	223,252,668.73
	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
	Бусад мөнгөн орлого	45,215,777.81	56,683,693.47
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>102,705,968,588.73</b>	<b>144,019,366,656.87</b>
	Ажиллагчдад төлсөн	28,802,784,069.99	46,049,400,143.33
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	5,699,505,515.00	9,821,333,442.71
	Бараа материал худалдан авахад төлсөн	27,178,814,519.17	32,105,961,299.76
	Ашиглалтын зардалд төлсөн	-	-
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	27,208,909,872.76	39,813,145,427.81
	Хүүний төлбөрт төлсөн	132,499,856.16	132,547,301.21
	Татварын байгууллагад төлсөн	12,414,905,986.43	14,907,385,790.66
	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
	Бусад мөнгөн зарлага	1,268,548,769.22	1,189,593,251.39
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>48,371,720,629.97</b>	<b>17,218,189,440.06</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>39,354,044,407.07</b>	<b>14,294,679,711.54</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	39,320,980,360.07	14,250,000,664.54
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	33,064,047.00	44,679,047.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(39,354,044,407.07)</b>	<b>(14,294,679,711.54)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>2,222,474,434.00</b>	<b>31,273,553,657.00</b>
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	2,222,474,434.00	31,273,553,657.00
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>10,893,299,263.16</b>	<b>31,268,648,788.97</b>
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	10,893,299,263.16	31,268,648,788.97
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(8,670,824,829.16)</b>	<b>4,904,868.03</b>
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>(4,619.93)</b>	<b>3,866,126.79</b>
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>346,846,773.81</b>	<b>2,932,280,723.34</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>703,196,034.90</b>	<b>1,050,042,808.71</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,050,042,808.71</b>	<b>3,982,323,532.05</b>

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 оны гүйцэтгэл	2022 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>А Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт биетээр</b>							
1	Нүүр гаргалт	мян.тн	4,341.6	4,343.6	4,404.5	60.9	101.4
2	Нүүрс борлуулалт	мян.тн	4,347.7	4,343.6	4,418.1	74.5	101.7
3	Хөрс хуулалт	мян.м <sup>3</sup>	19,901.6	15,470.0	16,509.8	1,039.8	106.7
4	Нийт уулын цул	мян.м <sup>3</sup>	31,043.7	25,138.7	27,645.6	2,506.9	110.0
<b>Б Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн үнийн дүнгээр</b>							
5	Нийт орлого	мян.төг	153,792,114.3	156,917,115.2	162,787,543.6	5,870,428.4	103.7
6	Үүнээс: Цэвэр орлого	мян.төг	152,292,931.7	156,699,392.0	160,262,944.9	3,563,552.9	102.3
<b>В Нийт зардал</b>							
7	Ерөнхий ба удирдлагын зардал	мян.төг	10,203,846.7	9,376,383.4	21,506,034.0	12,129,650.6	229.4
8	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	8,887,412.2	9,376,383.4	8,348,567.7	(1,027,815.7)	89.0
9	Нийгмийн зардал	мян.төг	2,618,069.0	2,971,121.6	2,756,750.2	(214,371.4)	92.8
<b>Г Татвар төлөхийн өмнөх ашиг</b>							
10	Цэвэр ашиг	мян.төг	1,510,158.9	(40,723,990.9)	(33,659,185.2)	7,064,805.7	82.7
11	Төсөвт төлөх нийт төлбөр	мян.төг	32,190,261.1	30,503,017.0	28,314,993.5	(2,188,023.5)	92.8
12	Үүнээс: Орлогын татвар	мян.төг	1,370,853.6	-	25,020.0	25,020.0	-
13	Ажиллагсдын тоо	хүн	1,139.0	1,123.0	1,123.0	-	100.0
14	Цалингийн сан	мян.төг	38,934,167.9	44,014,213.4	43,636,837.3	(377,376.1)	99.1
15	Авлага	мян.төг	9,210,780.6	9,210,780.6	10,823,785.2	1,613,004.6	117.5
16	Өр төлбөр	мян.төг	184,967,465.6	220,864,289.4	221,601,935.3	737,645.9	100.3
17	Үүнээс: Богино хугацаат өглөг	мян.төг	139,353,320.7	183,984,031.8	164,935,258.1	(19,048,773.7)	89.6
18	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	төгрөг	1.0	1.3	1.2		95.8
19	Хөрөнгө оруулалт	мян.төг	12,396,283.8	16,842,689.8	13,824,101.7	(3,018,588.1)	82.1
20	1 тонн нүүрсний өртөг	мян.төг	34,759.2	45,501.4	44,601.4	(900.0)	98.0
21	Хөрс хуулалтын коэффициент	м <sup>3</sup> /тн	4.6	3.6	3.8	0.2	105.3
22	Аваар саатал	тоо	-	-	-	-	-
23	Ус шүүрүүлэлт	мян м <sup>3</sup>	5,170.0	5,070.0	5,291.0	221.0	104.4
24	Байгаль орчин шинэчлэлт, иновацийн асуудлыг шийдсэн байдал	мян төг	32,281.4	477,814.3	63,561.1	(414,253.2)	13.3





### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Багануур ТӨХК-ийн эрхэм зорилго нь "Тогтвортой хөгжлийг хангасан, мэдлэг инновацид суурилсан үндэсний тэргүүлэгч компани болох"-д оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг нүүрсний олборлолт, баяжуулалт, боловсруулалт, борлуулалт, гадаад дотоод худалдаа, цайны газрын үйл ажиллагаа явуулах гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн өмчит хувьцаат компанийн статустай байна гэж заасан бөгөөд өмчийн 75 хувийг төрийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа Эрдэнэс Монгол ХХК, 21.06 хувийг Монголиан коал корпорейшн ХХК, 3.94 хувийг аж ахуйн нэгж, хувь хүмүүс эзэмшдэг. Мөн тус компани нь "Багануур сувилал" ХХК-ийн хувьцааг 100 хувь, "Мон цахим" ХХК-ийн хувьцааны 46 хувийг тус тус эзэмшдэг.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/16 дугаар тушаалаар баталсан "Уурхай, уулын баяжуулах, үйлдвэрийг ашиглалтанд хүлээн авах журам"-ын 2.1.2 дахь заалтыг үндэслэн Багануур ТӨХК-ийн нүүрсний ил уурхайг ашиглалтанд авах Улсын комиссын шийдвэр 2021 оны 12 дугаар сарын 24-нд гарсан. Энэ шийдвэртэй холбоотой 2022 оны эхний улиралд уурхайн дунд хугацааны ТЭЗҮ-г боловсруулж батлуулснаар уурхайн хүчин чадал 4-10 сая тоннд хүрч борлуулалт нэмэгдэх боломжтой болсон байна.

Мөн түүнчлэн 2022 онд компани Монгол Улсын Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 19.3.1 дэх заалтын дагуу Үндэсний итгэмжлэлтэйгээр менежментийн тогтолцооны стандартын баталгаажуулагч Мон Сертф ХХК-иас Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO 45001:2018 стандартын гэрчилгээг хүлээн авсан.

#### 3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Багануур ТӨХК нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын зөвлөлийн 1977 оны 368 дугаар тогтоолоор Төвийн эрчим хүчний системийн харьяа Дулааны цахилгаан станцуудыг нүүрсээр хангах зорилгоор байгуулагдсан байна. Монгол Улсын Засгийн газрын өмч хувьчлалын комиссийн 1993 оны 12 дугаар сарын 20-ны 63 дугаар тогтоолоор Багануур ТӨХК болгон өөрчилсөн бөгөөд 2012 оноос "Эрдэнэс Монгол" ХХК-ийн охин компани болон статус нь өөрчлөгдсөн.

Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд Компанийн тухай хуульд заасан хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхэд хамаарах асуудлуудаас бусад тохиолдолд бодлогыг Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ гэж шинэчлэсэн дүрэмдээ заасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;" гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын "2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.4.10-т "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно." гэж



заасан байна. Энэ хүрээнд Багануур ХК-ийн гүйцэтгэх захирлын 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А/240 дугаар тушаалаар "Үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, нөөцөнд тавих" журмыг батлан мөрдөж ажиллаж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд уурхайн хүчин чадлыг 5.7 сая тоннд хүргэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг тусгуулсан. Уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник шинэчлэлд нийт 33,500 сая төгрөгийг Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгуулсан. Тус хөрөнгө оруулалтыг 2023 онд авч техник, технологийн шинэчлэлийг хийх зайлшгүй шаардлага уурхайн өмнө тулгарч байна. Үүний үр дүнд ойрын жилүүдэд өсөн нэмэгдэж буй эрчим хүчний түлшийг найдвартай хангахад ихээхэн дэмжлэг болох нь тодорхой.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр батлагдаж хэрэгжихээр болсон.
- Хөдөлмөрийн тухай хууль 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр баталсан 2022 оноос эхлэн хэрэгжихээр болж, Хөдөлмөрийн тухай хуулийг дагаж мөрдөхтэй холбоотойгоор Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 сарын 06-ны өдрийн А/192 дугаар Дундаж цалин хөлс тодорхойлох журам батлагдсан. Уг журамд 2022 оны 3 сарын 17-ны өдрийн А/49 тоот тушаалаар нэмэлт оруулсан.
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлт орсон.
- Хувь хүний орлогын албан татварын хууль 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлт орсон.


Багануурын уурхайн хувьд Хөдөлмөрийн тухай хуулийн өөрчлөлт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжүүлэлттэй холбоотойгоор компанийн мөрдөн ажилладаг Хамтын гэрээ, хэлэлцээрийг шинэчлэн батлаагүй байна. Үүнтэй холбоотойгоор Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3, 15.1.5, 15.2.3 зэрэг заалтууд хэрэгжихгүй байна.

Мөн уурхайн санхүү, нягтлан бодох бүртгэлдээ мөрддөг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж мөрдөн ажиллаагүй байгаа нь өмнөх жилээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөгүй байна.

Багануур ТӨХК-ийн ТУЗ-ийн 2014 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 28 дугаар тогтоолоор батлагдсан "Компанийн дотоод хяналт шалгалтын албаны ажиллах журам"-ын дагуу үйл ажиллагаа явуулдаг бөгөөд өмнөх оны санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжөөр компанийн Дотоод хяналт шалгалтын алба, түүний даргын үйл ажиллагааг хангалтгүй гэж дүгнэсэн. Үүнтэй холбоотойгоор Багануур ХК-ийн ТУЗ-ийн зөвлөлийн 2022 оны 4 сарын 22-ны өдрийн 01 тоот тогтоолоос Аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж, хэрэгжилтийг Төлөөлөн удирдлах зөвлөлд тайлант оны эхний хагаст багтаан танилцуулах үүрэг, даалгавар өгсөн байна. 2022 оны 9 сарын 12-ны өдрийн Б/313 тоот тушаалаар Дотоод хяналт шалгалтын албаны дарга шинээр томилогдсон.

Дотоод хяналт шалгалтын албаны зүгээс төлөвлөгөөт, төлөвлөгөөт бусаар хийгдсэн ажлуудын хүрээнд дотоод хяналтанд хамрагдсан хэлтэс тасгуудад заавар зөвлөмж хүргүүлэн ажилласан байна. Харин заавар зөвлөмжийн биелэлтийн үр дүн харилцан





адилгүй гарчээ. Тайлант онд хэрэгжиж эхэлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хянах чиглэлээр дорвитой ажил хийгээгүй бөгөөд зөвхөн гар утасны хөнгөлөлт, тээврийн хэрэгслийн ашиглалттай холбоотой хяналтуудыг хийж бусад зүйл, заалттай холбоотой хяналтыг 2023 онд хийхээр төлөвлөсөн байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд тусалцаа авах/ шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Багануур ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Эрдэнэс Монгол ХХК-ийн группын хэмжээний 2018 онд баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тус компани санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна. Багануур ХК-ийн мөрдөж байгаа уг НБББББ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

Энэ нь компанийн бизнесийн үйл ажиллагаа болон бүртгэлийн нийтлэг зарчмыг зарим талаар хангахгүй, шинэчлэн өөрчлөгдсөн СТОУС, НББОУС-ын утга агуулгыг бүрэн тусгаагүй байгаа зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа талаар өмнөх аудитаар зөвлөмж өгсөн ч одоо болтол шийдвэрлэгдээгүй байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт**

Багануур ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн тусгай бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,689.0 сая төгрөгөөр буюу 3 хувиар буурсан байна.

Багануур ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,050,043	3,982,324	2,932,281
Худалдааны болон бусад авлага	9,210,781	10,823,785	1,613,005
Урьдчилгаа	9,323,480	10,839,247	1,515,767
Бараа материал	32,943,859	45,001,907	12,058,048
Үндсэн хөрөнгө	176,950,746	151,858,947	(25,091,799)
Биет бус хөрөнгө	34,048,415	33,332,099	(716,316)
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>263,527,323</b>	<b>255,838,309</b>	<b>(7,689,014)</b>
Богино хугацаат өглөг	139,353,321	164,935,258	25,581,937
Урт хугацаат өглөг	45,614,145	56,666,677	11,052,532
Эздийн өмч	78,559,857	34,236,373	(44,323,484)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>263,527,323</b>	<b>255,838,309</b>	<b>(7,689,014)</b>

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх 2021 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах дансдууд байна. Үүнд:


Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 3,982.3 сая төгрөг болж өссөн. Үүнээс касс дахь бэлэн мөнгөний эцсийн үлдэгдэл 1.6 сая төгрөг, банк дахь харилцах дансанд 2,480.8 сая төгрөг, замд яваа мөнгө 1,500.0 сая төгрөг байна.

Худалдааны болон бусад авлагын тайлант оны эцсийн үлдэгдэл 10,823.8 сая төгрөг болж 1,613.0 сая төгрөгөөр өссөнийг авлагын ангиллаар нь авч үзвэл: Борлуулалтын авлагын хувьд тайлант хугацаанд компанийн авлага 1,552.7 сая төгрөгөөр буурсан бөгөөд голлох худалдан авагчид болох ДЦС-3 болон ДЦС-4-өөс борлуулалтын авлагыг 100 хувь цуглуулсан нь чухал нөлөөг үзүүлсэн. Харин Багануурын ДЦС-аас авах авлага тайлант үеийн эцэст 1,915.1 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1,254.2 сая төгрөгөөр, Амгалангийн ДЦС-аас авах авлага 453.3 сая төгрөгөөр тус тус өссөн. Мөн түүнчлэн гадаадын авлагын өсөлтөнд Оросын холбооны улсын Транс техно маркет ХХК-ийн 2,382.5 сая, Линкер ХХК-ийн 188.3 сая төгрөгийн сэлбэгийн материалуудыг тайлант онд хүлээн авч амжаагүй нь нөлөөлсөн. Багануур ХК нь найдваргүй авлагыг нөөцийн буюу хасагдуулгын аргаар тооцдог байна. Тайлант онд 524.1 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц байгуулж, тайлант хугацаанд данснаас хассан найдваргүй авлага гараагүй байна.

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд Уулын дэд станцыг нүүлгэн шилжүүлэх ажлын урьдчилгаанд төлсөн 3,750.0 сая төгрөгийн, Төмөр зам нүүлгэн шилжүүлэх ажлын төлбөрт төлсөн 982.9 сая төгрөгийн, уурхайн ТЭЗҮ хийхэд урьдчилж төлсөн 550.0 сая төгрөгийн дүнгүүд тусгагдсан ба 2022 онд дэд станц шилжүүлэх ажилд 1,060.0 сая төгрөгийн төлбөр нэмж төлсөнтэй холбоотойгоор тайлант хугацааны урьдчилгаа данс өссөн. Харин дээрх ажлуудыг тайлант хугацаанд хүлээн аваагүй нь Шүдэн зам ХХК гүйцэтгэгчтэй төмөр замын нүүлгэлтийн ажил бүрэн дуусаагүй, Хасуу эрчим ХХК-ийн гүйцэтгэсэн дэд станц шилжүүлэх ажил бүрэн дууссан боловч ажлын гүйцэтгэлийн үнэлгээ өөрчлөгдсөний улмаас тухайн ажлыг хүлээлгэж өгөөгүй холбоотой байна. 2012 онд үүссэн ТЭЗҮ хийх урьдчилгаа төлбөр хүлээн авагч Гложекс ХХК-ийг компанийн зүгээс шүүхэд өгч асуудлыг шийдвэрлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Бараа материалын үлдэгдэл 45,001.9 сая төгрөг болж 12,058.0 сая төгрөгөөр өссөн нь 10,608.1 сая төгрөгийн хөрөнгийг аудитын зөвлөмжийн дагуу үндсэн хөрөнгийн данснаас бараа материалын данс болох САТ, Komatsu-гийн сэлбэг, Цахилгааны болон Эскаваторын сэлбэг хэрэгсэл данснуудад хөрөнгийн ангилал сольж бүртгэсэн, мөн

СНАГ-2023/58/НА-СТА-ТӨА





КОВИД-19 цар тахлын дараах үр дагавар, хойд хөршид үүссэн цэрэг дайны үйл ажиллагааны улмаас үүссэн нэн шаардлагатай нефтийн бүтээгдэхүүн, тэсрэх материал, төмөр бэлдэц, сэлбэг материалын үнийн огцом өсөлтүүдээс шалтгаалсан байна. Бараа материалын дансны үлдэгдэлд үнэ цэнийн бууралт хийсэн таван жилээс дээш эргэлтэнд ороогүй 1745 нэр төрлийн 3,926.0 сая төгрөгийн бараа материал байна. Эдгээр нь хуучин ашиглаж байсан D-155A, HD-405, Белаз 7555, TEREX/60-A4 техник тоног төхөөрөмжүүдийн ашиглагдахаа больсон сэлбэг материал тул эргэлтэнд ороогүй хэвээр байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл тайлант онд 3,068.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авалтаар, 13,103.9 сая төгрөгийн их засварын зардлын капиталжуулалтаар тус тус нэмэгдэж, аудитын зөвлөмжийн дагуу бараа материалын дансууд руу хөрөнгийн ангилал сольж шилжүүлсэн 10,977.1 сая төгрөгийн хөрөнгөөр буурч, 27,601.6 сая төгрөгийн элэгдлийн зардлаар хорогдсон. Мөн тайлант хугацаанд 263.4 сая төгрөгийн ачигч краны эд ангийг Шивээ овоо ХК руу эргэж буцах нөхцлөөр шилжүүлсэн. Тайлант онд акталсан хөрөнгө байхгүй.

Биет бус хөрөнгө 716.3 сая төгрөгөөр буурсан нь ашигт малтмалын лиценз, уул уурхайн бүртгэл төлөвлөлт, бүртгэл хөтөлдөг Минекс, План ворк, бусад программ хангамжуудын элэгдэл, хорогдол, хөгжүүлэлтийн зардалд 220.1 сая төгрөгийг, уул уурхайн хөрөнгөтэй холбоотойгоор хөрс хуулалтын 540.9 сая төгрөгийн зардлыг тус тус бүртгэснээс шалтгаалжээ.

Багануур ТӨХК нь Багануур сувилал ХХК, Багануур илч ХХК гэсэн 2 охин, Мон цахим ХХК гэсэн нэг хараат компанитай, эдгээр урт хугацаат хөрөнгө оруулалтын дүнд өөрчлөлт ороогүй. Мөн түүнчлэн компани нь тайлант ондоо хойшлогдсон татварын хөрөнгөө ашиглаагүй байна.

Богино хугацаат өр төлбөр дансны хувьд оны эхний үлдэгдэл 139,353.3 сая төгрөг байсан бол оны эцэст 164,935.3 сая төгрөг болж 25,581.9 сая төгрөгөөр өссөн нь бэлтгэн нийлүүлэгч компаниудад төлөх өр 10,853.7 сая төгрөгөөр, цалингийн өглөг 794.2 сая, нийгмийн даатгалын өр 1,270.2 сая, татварын өр 11,669.3 сая, зээлийн хүүний өр 841.0 сая төгрөгөөр, богино хугацаат зээл 1,830.7 саяар нэмэгдэж, бусад өр төлбөр 1,677.2 саяар буурсантай холбоотой.

Дээрх өөрчлөлтийн заримаас товч дурдвал: Дансны өр төлбөрийн хувьд Улсын Онцгой комиссын шийдвэрийн дагуу Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын 05 дугаар ангиас олгосон 1,249.2 сая төгрөгийн, Шунхлай компаниас оны эцэст хийгдсэн дизель түлшний 911.0 сая төгрөгийн, 1,976.4 сая төгрөгийн Эрдэнэс монгол ХХК-д төлөх тайлант оны менежментийн төлбөр, 3,524.6 сая төгрөгийн Шүүхийн шийдвэрээр тооцсон Зуун найман ойл ХХК-тай холбоотой торгуулийн алданги, 1,321.2 сая төгрөгийн ДЦС-3, ДЦС-4-өөс урьдчилж төлсөн нүүрсний төлбөрүүд өсөлтөд голлох нөлөөлөл үзүүлсэн.

Орлогын татварын өсөлтийн хувьд Татварын ерөнхий газрын дэргэдэх татварын маргаан таслах зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 03 тоот тогтоолын дагуу Багануур ТӨХК-ийг татвар ногдуулалт, төлөлттэй холбоотой зөрчилд 10,820.6 сая төгрөгийн төлбөрийг төлүүлэхээр шийдвэрлэсэн нь нөлөөлсөн.

Харин урт хугацаат өр төлбөрийн хувьд оны эхэнд 45,614.1 сая төгрөг байсан бол оны эцсээр 56,666.7 сая төгрөг болж 11,052.5 сая төгрөгөөр өссөн байна. Урт хугацаат өр төлбөр дансанд 1998-2000 оны хооронд Монгол нүүрс төслийн хүрээнд авсан MOG-2854 зээлийн 9,382.9 сая төгрөг, толгой компани болох Эрдэнэс-Монгол ХХК-иас авсан 10,061.8 сая төгрөг, 2021 онд техник технологийн шинэчлэлтийн ажлын хүрээнд Японы Олон Улсын хамтын ажиллагааны банкны /JBIC/ зээлийн шугамын хүрээнд Сангийн



яамаар дамжуулан авсан зээлийн үлдэгдэл 18,681.6 сая төгрөгийн зээл бүртгэлтэй байна. Дээрх зээлүүдээс гадна нүүрсний салбарыг хөгжүүлэх төслийн хүрээнд авсан MON-P4 зээлийн 416.9 сая төгрөгийн урт хугацааны зээлийн үлдэгдэл төлбөрийн ангиллыг сольж богино хугацаат зээл рүү шилжүүлсэн. Мөн МОГ-2854 зээлээс 1,109.2 сая төгрөгийн зээлийг богино хугацааны зээл рүү шилжүүлсэн.

Уурхай өөрийн өвөлжилтийн бэлтгэлийг хангах зорилгоор 23,900.0 сая төгрөгийн дүн бүхий ЭТТ-2022/862 тоот зээлийн гэрээг 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Эрдэнэс таван толгой ХХК-тай байгуулж 9,270.0 сая төгрөгийг тайлант хугацааны сүүлээр хүлээн авсан. 2022 оны явцын аудитын зөвлөмжийн дагуу эздийн өмч хэсэгт тусгагдсан байсан 9,270.8 сая төгрөгийн дүн бүхий нөхөн сэргээлтийн нөөц сан, тэтгэврийн нөөц сан, нийгмийн хөгжлийн сангуудыг урт хугацаат өр төлбөр хэсэгт тусгасан. Эдгээр нь урт хугацаат өр төлбөр өсөхөд голлох нөлөөллийг бий болгосон.

Тайлант оны эцсээр компани компани Японы Олон Улсын хамтын ажиллагааны банкны зээлээсээ 3,668.1 сая төгрөг буюу 156,959,881.47 японы иенийг борлуулалтын авлагаараа төлж барагдуулсан. Тус зээлтэй холбоотойгоор 1,607.9 сая төгрөгийн валютын ханшийн гарзыг компани хүлээн зөвшөөрч бүртгэлдээ тусгасан.

Урт хугацаат өр төлбөрийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэхгүй байгаа нь Эрчим хүчний зохицуулах хорооноос цахилгааны үнэ тарифыг нүүрсний үнээс нь доогуур тогтоож ирснээс шалтгаалсан.

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хөрөнгийн бууралт эсвэл өр төлбөрийн өсөлттэй холбоотой эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийн бууралт үүссэн үед зардлын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг найдвартай хэмжих боломжтой үед зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд өртөг, зардлын талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал, борлуулалт, маркетингийн зардал, ерөнхий ба удирдлагын зардал гэж ангилсан.

Зардал өмнөх онтой харьцуулахад 45,508.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь цар тахал буюу КОВИД19-ийн дараах нөлөө, хойд хөршид өрнөсөн дайны үйл ажиллагаанаас улбаатай гол импортын бараа, бүтээгдэхүүнүүд болох нефтийн бүтээгдэхүүн, тэсрэх хэрэгсэл, төмөр хэв бэлдэц, сэлбэг хэрэгсэлд үнийн огцом өсөлт бий болоход том цохилт болсон байна. Үүний хажуугаар урд хөршид үүссэн КОВИД19-ийн нөлөө мөн оны дунд үе хүртэл байсан нь тээвэр ложистик үнийн хөөрөгдөлд өртөж, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөө үзүүлжээ. Дээрх гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийн эрсдэл одоо ч байсаар байна.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Багануур ХК-ийн удирдлага үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Багануур ТӨХК-ийн удирдлага ТУЗ-ийн 2022 оны 19 дүгээр тогтоолоор 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тодотгож баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 156,917.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 197,641.1 сая төгрөгөөр, 40,724.0 сая төгрөгийн алдагдалтай баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 16,842.7 сая төгрөгийг төлөвлөжээ.





Гүйцэтгэлээр 162,787.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 196,446.7 сая төгрөгийн зардал гарган, 33,659.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 162,787.5 сая төгрөг болж төлөвлөснөөс 5,870.4 сая төгрөг буюу 3.7 хувиар давсан нь Эрчим хүчний зохицуулах хорооноос аж ахуйн нэгжүүдийн эрчим хүчний үнийг нэмэгдүүлж түүнээс орсон орлогыг эрчим хүчний компаниудад хуваарилах байдлаар компанийн 1 тонн нүүрсний үнийг 2022 оны 11 сарын 25-ны өдөр 29 хувиар нэмэгдүүлж 43,310 төгрөгт хүргэх шийдвэр гаргасныг бизнес төлөвлөгөөнд тодотгосон, мөн онд ДЦС-2, 3, 4, Дарханы ДЦС, Эрдэнэтийн ДЦС-уудад төлөвлөгөөр 3,897.0 мянган тонн нүүрс борлуулахаас 73.9 мянган тонн, жижиг хэрэглэгчдэд 226.6 мянган тонн нүүрс нийлүүлэхээс 19.3 мянган тонн нүүрсийг тус тус илүү, орон нутгийн станцуудын хувьд 18.6 мянган тонн нүүрс дутуу нийлүүлсэн буюу нийт тоон үзүүлэлтээр 74.5 мянган тонноор борлуулалтын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн зэргээс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 196,446.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,194.4 сая төгрөг буюу 0.6 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь хөрс хуулалт, тэсэлгээний зардлыг бууруулахын тулд тэсэлгээ, хөрс хуулалт шаардахгүй хэсгийн олборлолтыг нэмэгдүүлж, нүүрсний чанарыг дундажлах ажлыг зохион байгуулсны үр дүнд 553.6 сая төгрөгийн, ашиглалтын шаардлага хангахгүй болсон хөрөнгийг дахин засварлаж ашигласнаар төмрийн зардлыг 149.1 сая төгрөгийн, зам овоолгын хүнд даацын техникүүдийн ашиглалт багатайгаас түлшний хэрэглээг бодитоор хэмнэж 812.2 сая төгрөгийг, тос тослох материалын биет хэмжээг үйлдвэрлэлийн цехүүдэд бий болгосноос 1,035.6 сая төгрөгийн, аудитын зөвлөмжийн дагуу урсгал засвараар гарах байсан сэлбэгийг хөрөнгөнд капиталжуулалт хийснээр 3,178.5 сая төгрөгийн хэмнэлтийг тус тус бий болгосон нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 3 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 8,175.1 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 33,659.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 7,064.8 сая төгрөгөөр дутуу байгаа нь төлөвлөгөөт нүүрсний борлуулалтыг 74.5 мянган тонноор нэмэгдүүлж, олборлолтын голлох зардлууд болох хөрс хуулалт, тэсэлгээ, сэлбэг хэрэгсэл, түлшний зардлуудыг бодит хэмжээгээр тус тус бууруулсан нь нөлөөлжээ.

#### 4. АУДИТЫН ТАЙЛАН

##### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Багануур ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Багануур ХК-ийн үйл ажиллагааг сайжруулах авлага, өглөгийн үлдэгдлийг харилцагч бүрээр тооцоо нийлж баталгаажуулах, үүссэн тооцоог нь хооронд нь хаахгүй байх, дараа тайланг цаг хугацаанд нь хааж найдваргүй авлага үүсэхээс сэргийлэх, ажилчдын эрүүл мэндийн даатгалын суутгалыг хуульд заасны дагуу суутгах, ТБОНӨХБҮХАТ хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Нийслэл-Аудит ХХК-ийн ахлах аудитор Л.Ганзориг, аудитор Г.Жаргал, И.Шүрэнцэцэг, Д.Энхтуяа нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Г.Жаргал, захирал Т.Сугарсүрэн нар тус тус хэрэгжүүлсэн.

Багануур ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2023 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 01/175 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

##### 4.2 Материаллаг байдал


Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2021 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 150,911.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1,509.1 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

##### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Багануур ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/132 дугаар тушаалаар Хэмнэлтийн төлөвлөгөөг баталсан. Уг тушаалаар компанийн удирдлагуудад үйлчилж буй жагсаалтанд дордсан авто машинуудыг зөвхөн албаны хэрэгцээнд, гар утасны ярианы төлбөрийг компаниас төлөхгүй байхыг чиг үүрэг болгож Автомашин ажиглах түр журам боловсруулсан байна.

Багануур ТӨХК-ийн 2022 оны хэмнэлтийн төлөвлөгөөг компанийн гүйцэтгэх захирал 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдөр баталсан байна. Уг төлөвлөгөөнд хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулах замаар илүү цагийг бууруулах, сэлбэгийн эд ангиудыг сэргээн засварлаж дахин ашиглах, ашиглалтын зардлыг хэмнэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх, шатах тослох материалын зардлын гүйцэтгэлд хяналт тавьж хэмнэлт бий болгох үндсэн чиглэл тусгагдсан бөгөөд энэ үр дүнгээ өгч илүү цагаас 195.5 сая





төгрөгийг, ашиглалт-цахилгааны зардлаас 763.0 сая, шатах тослох материалаас 305.8 сая, засварын үйл ажиллагаанаас 627.7 сая төгрөгийг нийт 1,892.0 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Хэдийгээр тодорхой ажлуудыг зохион байгуулж үйл ажиллагааны хүрээнд тодорхой хэмнэлтийг бий болгож чадсан боловч хэмнэлтийн хуулийн хүрээнд өөрийн байгууллагын онцлогт тохируулж Хамтын гэрээний зүйл заалтад өөрчлөлт оруулаагүйгээс тэмдэглэлт ойн баяр, спортын арга хэмжээ, уралдаан, өдөрлөг, зочид гийчдийг хүлээн авах, төрийн дээд одон медаль авахтай холбоотой их хэмжээний мөнгөн болон мөнгөн бус зүйлсийг зарцуулсан байна.

Тайлант хугацаанд компанийн ажилтнуудыг танхимын дараах сургалтуудад хамруулж нийт 8.5 сая төгрөг зарцуулсан.Үүнд: 1.3 сая төгрөгийг Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс зохион байгуулсан сургалтанд, Монголын дотоод хяналт эрсдэлийн удирдлагын хөгжил холбооны сургалтанд 1.2 сая төгрөгийг, Карьер эйд ХХК-ийн сургалтанд 3.2 сая төгрөг, 1.2 сая төгрөгийг Мэдээлэл технологийн үндэсний төвийн сургалтанд, ШУТИС-иас зохион байгуулсан сургалтанд 1.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т "сургалт, семинар, хурал зөвөлгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төрийн дээд шагнал, одон медаль хүртсэн ажилтнууд болон ойн арга хэмжээ, тэмцээн уралдаантай холбоотой шагнал, бэлэг дурсгалд 64.3 сая төгрөгийг зарцуулсан. Үүнээс мөнгөн аяга авахад 33.5 сая төгрөгийг, бусад бэлэг дурсгал болох медаль, өргөмжлөл зэрэгт 30.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал урамшуулал, дэмжлэг олгох"-ыг гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

2022 онд Шилэн дансны цахим хуудсанд 6 төрлийн 171 мэдээллийг оруулахаас 166 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Өмнөх

## Багануур ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

оны аудитын зөвлөмжөөр өгсөн зөрчил, явцын аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хангаж, оруулбал зохих мэдээллүүдийг бүрэн тусган ажилласан нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаж байна.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Компани 2022 онд бараа, ажил үйлчилгээ худалдан авах 37,821.2 сая төгрөгийн 598 гэрээ байгуулснаас 33,302.3 сая төгрөгийн үнийн дүнтэй 271 гэрээний бэлтгэн нийлүүлэгчийг нээлттэй тендерээр шалгаруулсан. Харин ТБОНӨХБАУХА тухай хууль, Засгийн газрын 124 дүгээр тогтоолын холбогдох заалтыг зөрчин 20.0 саяаас 100.0 сая төгрөгийн үнийн дүнтэй 212 гэрээний бэлтгэн нийлүүлэгчтэй 10,820.3 сая төгрөгийн гэрээг шууд байгуулсан нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* ТБОНӨХБАУХА тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Багануур ТӨХК-ийн 2022 оны гуравдугаар улирлын байдлаар санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудитыг санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн хувьд аудитын горим, сорил, биет тест хийх байдлаар хийж гүйцэтгэлээ. Компанийн шинээр томилогдсон удирдлагын бие бүрэлдэхүүнтэй уулзалт ярилцлагуудыг хийж баталгаажуулж ажиллав.

Завсрын аудитын асуудлын бүртгэлээр 10 асуудлын хүрээнд 12,684.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 12,411.4 сая төгрөгийн алдааг залруулж, 272.7 сая төгрөгийн алдаа зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 61,878.6 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 15,852.0 сая төгрөгийн 8 алдааг залруулж, 3 зөвлөмж өгснөөс 3 албан шаардлага, 3 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөвлөмж 53 хувийн биелэлттэй байна.

*Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	4	46,026,560.2	1	24,232,261.0	53%
Зөвлөмж	3	0	0	0	
Нийт дүн	7	46,026,560.2	1	24,232,261.9	53%

Өмнөх аудитын албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг гаргуулан, нотлох баримтуудыг цуглуулан тулгалт хийхэд шилэн данстай холбоотой 1 албан шаардлагыг бүрэн биелүүлж, бусад албан шаардлага, зөвлөмжийг биелүүлээгүй байна. Энэ дараах шалтгаантай холбоотой. Үүнд:

СНАГ-2023/58/НА-СТА-ТӨА





1. Компани санхүүгийн үйл ажиллагаандаа ажиллаж байгаа бодлогын баримт бичиг нь одоогийн мөрдөгдөж байгаа олон улсын стандарт, шинэчлэгдсэн хууль, дүрэм журамтай нийцэхгүй байна. Үүнтэй холбоотойгоор Эрдэнэс монгол ХХК групп компанийн хэмжээнд бодлогын баримт бичгийг дахин шинэчлэн боловсруулах тендерийг 2022 онд зарлан гүйцэтгэгч шалгарсан боловч компанийн удирдлага солигдсоноос шалтгаалж тус ажил зогсонги байдалд орсон.
2. Компанийн хамтын гэрээний 4.3.6-д заасны дагуу ажиллагсдын төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 1 хувийг компаниас төлж байгаа нь холбогдох хуулийн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд үүнийг компанийн зүгээс хууль зөрчөөгүй гэж үзэн тайлант хугацаанд төлсөн хэвээр байна.
3. Компани нягтлан бодох бүртгэлдээ Сангийн сайдын 2000 оны 116 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт, 2017 оны 248 дугаар баталсан нягтлан бодох бүртгэлийн маягт, аргачлалыг тус тус мөрдөж байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Толгой компанийн удирдлага солигдсоноор тус асуудалтай холбоотой ашиглаж буй бодлогын баримт бичиг, програм хангамжийг шинэчлэх асуудал тодорхойгүй шалтгаанаар хойшилсон байна.
4. Бараа ажил үйлчилгээ худалдан авах 20-100 сая төгрөгийн үнийн дүнтэй худалдан авалтыг бэлтгэн нийлүүлэгчтэй шууд гэрээ байгуулах замаар хийж байгаа асуудал тайлант 2022 оны хувьд үнийн дүнгийн хувьд буурсан ч байсаар байгаа нь тус асуудал биелээгүйг харуулж байна. Нөгөө талаас компанийн санхүүгийн төлбөрийн чадвар маш муу байдгаас хуримтлагдсан өр ихээр үүсч компаниас зарласан тендер, худалдан авах ажиллагаанд оролцох бэлтгэн нийлүүлэгчдийн сонирхлыг бууруулах, үргээх нөхцөл байдал үүсгэдэг нь тухайн асуудлыг бодлогын түвшинд яаралтай шийдвэрлэх ёстойг харуулж байна.
5. Компани өмнөх оны эцсээр 711.2 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байсан ба тайлант хугацаанд баталгаажуулаагүй авлагын дүн өссөн байгаа нь тухайн тайлант хугацаанд компанийн авлага хариуцсан нягтлан бодогч гурван удаа солигдсон үүнд нөлөөлсөн байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараа тайлан тооцооны баримтын бүрдэл, авлага өр төлбөрийг хооронд нь хааж байгаа эсэх, тэдгээрийн баталгаажилт, мөн урьдчилж төлсөн тооцоо болон зардлын хаалт, хуримтлагдсан элэгдэл, татварын тооцоолол зэргийг авч үзэх шаардлагатай гэж үзлээ. Тайлант хугацаанд үүссэн алдаа, зөрчилтэй холбоотойгоор эдгээр асуудлыг сонгож оруулав.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12,684.1 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 12,411.4 сая төгрөгийн алдааг залруулж, 272.7 сая төгрөгийн алдаа зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

- Үндсэн хөрөнгийн шинж чанарыг агуулаагүй бараа материалын шинж чанарыг агуулсан 11,236.3 сая төгрөгийн дүн бүхий хөрөнгийг компанийн Агуулахад байгаа үндсэн хөрөнгөнд тусгасан.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхиуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга ханбсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

## Багануур ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

- Дуусаагүй үйлдвэрлэлийн зардалд 1,005.8 сая төгрөгийн сэлбэг материал, техник хэрэгслийг капиталжуулалт хийлгүйгээр бүртгэжээ.
- Үндсэн хөрөнгийн шинж чанартай 33.0 сая төгрөгийн өртөг бүхий хийн буу, 72.7 сая төгрөгийн ус нэрэх станцыг сэлбэг материалаар бүртгэсэн байна.
- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүнтэй 1,837.9 сая төгрөгийн зарлагын гүйлгээний мэдээллийг үнэн зөв, бүрэн оруулаагүй.
- Ажилтны 28.4 сая төгрөгийн нэг удаагийн нөхөн олговрыг Тэтгэврийн сан данснаас зарцуулсан.
- Тэтгэврийн сангийн дансыг хорогдуулах замаар ААХ-аас авах авлагыг 4.7 сая төгрөгөөр бууруулж ажилтны дараа тайлангийн тооцоог хаасан.
- Байгууламжийн хуримтлагдсан элэгдэл дансны дэлгэрэнгүй бүртгэлээрх эхний үлдэгдэл, ерөнхий дэвтрийн эхний үлдэгдлээс 4.5 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсан.
- Хамтын гэрээгээр олгогддог нэг удаагийн тэтгэмжийн зардалд Хүүхдээ асарч буй чөлөөтэй эхэд ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг, мөн нас барсан ажилтны ХЧТА-ны тэтгэмж, Жирэмсэн ажилтны тэтгэмжийг зэрэг нийт 20.3 сая төгрөгийг бүртгэсэн.
- ТУЗ-тэй холбоотой 0.3 сая төгрөгийн томилолтын зардлыг байгууллагын удирдлагын зардал дансанд зардлын ангилал зөрүүлж тусгасан.
- Тээврийн хэрэгслийн түлшний саван дахь 5.4 сая төгрөгийн үлдэгдлийн тооцоог бүртгэлд тусгаагүй байна.

Аудитаар нийт 24,326.3 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 33.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 24,293.3 сая төгрөгийн албан шаардлага хүргүүллээ.

### 5.1 Төлбөрийн акт


Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд жилийн үр дүнгийн шагнал гэж 33.0 сая төгрөг олгосон байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.12-т "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Олгосон үр дүнгийн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

### 5.2 Албан шаардлага

Багануур ТӨХК-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд нийт 15,298.8 сая төгрөгийн авлага тайлагнаснаас 157 харилцагчийн 3,234.8 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаа нь ТБОНӨТХ-ийн 71 дүгээр зүйлийн 71.8-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь өр авлагыг барагдуулж ажиллах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудтай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага; түүний удирдлага; байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.





Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

Компанийн санхүүгийн тайланд тусгагдсан 9,407.3 сая төгрөгийн дансны өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байгаа нь ТБОНӨТХ-ийн 71 дүгээр зүйлийн 71.8-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь өр авлагыг барагдуулж ажиллах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудтай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

Хамтын гэрээний дагуу ажилтнаас төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлд тайлант онд 375.9 сая төгрөгийг байгууллага хариуцан төлсөн нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1-т "Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь 2 байна" гэсэн заалтыг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн дагуу эрүүл мэндийн даатгалыг ажилтнаас суутган, тус зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Эргэлтийн бус хөрөнгийн данснаас 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Шивээ овоо ТӨХК руу 263.4 сая төгрөгийн өртөг бүхий алхагч краны эд ангийг эргэн буцах нөхцөлөөр дээд шатны байгууллагын шийдвэргүйгээр, компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар шилжүүлсэн нь ТБОНӨТХ-ийн 31.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгийг, ... худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно", 31.2-т "Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд хөрөнгийг худалдах, шилжүүлэхэд энэ хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авна.", 30.2-т "Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, Засгийн газраас зөвшөөрөл олгосон тохиолдолд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх;

Нотлох баримтаар бүрэн хангагдаагүй байхад авлага, өглөгийн тооцооны үлдэгдлийг харилцагч хооронд хааж бүртгэсэн, өөрөөр хэлбэл харилцагчаас ирүүлсэн албан тоотыг үндэслэн нэг харилцагчийн тооцоог, нөгөө харилцагч руу хаах байдлаар бүртгэл хөтлөн явуулж байна. Энэ нь Санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлалын үнэн зөв толилуулах, шалгах боломжтой байх зэрэг чанарын шинжүүд, мөн НББОУС 32-ын Санхүүгийн хэрэглүүр: Параграф 42: Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийг харилцан суутгаж цэвэр дүн гаргалт хэсэгт тусгасан зүйлстэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

Багануур ТӨХК-ийн мөрдөж буй "Дараа тайлангаар бэлэн мөнгө олгох, тооцоог хааж журмын дагуу дараа тайлан нь хугацаандаа хаагдахгүй байгаагаас авлага найдваргүй болох, баталгаажигдахгүй байх нөхцөл үүсч байна. Тухайлбал: Дараа тооцооны 62.7 сая төгрөгийн ажил гүйлгээг нь харилцагчийн өргөдөл, албан тоот, хүсэлтийг үндэслэн хааж, 66.0 сая төгрөгийн тооцоо нь журамд заасан хугацаанд хаагдаагүй. нийт 118.7 сая

Багануур ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

төгрөгийн зөрчил гарсан байгаа нь журмын 5.1.1-т "сэлбэг бараа материал, бусад хангамжийн зүйлс худалдан авахаар бэлэн мөнгө авсан бол Улаанбаатар хот дотор худалдан авалт хийхээр бэлэн мөнгө авснаас хойш ажлын 10 хоногийн дотор, гадаад улс болон бусад аймаг орон нутагт худалдан авалт хийхээр бэлэн мөнгө олгогдсоноос хойш 10 хоногийн тайланг тушааж тооцоог хийнэ" гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг дахин гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх;

**5.2 Зөвлөмж**

Жилийн эцсийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.





Багануур ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэлтэл

/Мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Запруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Ажилтны 28.4 сая төгрөгийн нэг удаагийн нөхөн олговрыг Тэтгэрийн сан данснаас зарцуулсан.	1	28,418.0			1	28,418.0							
Тэтгэрийн сангийн дансыг хорогдуулах замаар ААХ-аас авах авлагыг бууруулж ажилтны дараа тайлангийн тооцоог хаасан.	1	4,720.8			1	4,720.8							
ТУЗ-тэй холбоотой томилолтын зардлыг удирдлагын зардал дансанд зардлын ангилал зөрүүлж тусгасан.	1	263.8			1	263.8							
Байгууламжийн хуримтлагдсан элэгдэл дансны дэлгэрэнгүй бүртгэлээрх эхний үлдэгдэл, ерөнхий дэвтрийн эхний үлдэгдлээс зөрүүтэй тайлагнагдсан.	1	4,470.3			1	4,470.3							
Үндсэн хөрөнгийн шинж чанарыг агуулаагүй бараа материалын шинж чанарыг агуулсан хөрөнгийг компанийн Агуулахад байгаа үндсэн хөрөнгөнд тусгасан.	1	11,236,284.3			1	11,236,284.3							
Хамтын гэрээгээр олгогддог нэг удаагийн тэтгэмжийн зардалд НДШ-ийн зардал, нас барсан ажилтны ХЧТА-ны тэтгэмж, жирэмсэн ажилтны тэтгэмж зэргийг бүртгэсэн.	1	20,270.1			1	20,270.1							
Дуусаагүй үйлдвэрлэлийн зардалд 1,005.8 сая төгрөгийн сэлбэг материал, техник хэрэгслийг капиталжуулалт хийлгүйгээр бүртгэжээ.	1	1,005,841.1			1	1,005,841.1							
Тэвэрийн хэрэгслийн түлшний саван дахь үлдэгдлийн тооцоог бүртгэлд тусгахгүй байна.	1	5,365.1			1	5,365.1							
Үндсэн хөрөнгийн шинж чанартай 33.0 сая төгрөгийн өртөг бүхий хийн буу, 72.7 сая төгрөгийн ус нэрэх станцыг сэлбэг материалаар бүртгэсэн байна.	1	105,727.3			1	105,727.3							
Хамтын гэрээний дагуу ажилтнаас төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг байгууллага хариуцан төлж зардлын өсгөсөн байна.	1	272,728.3			1	272,728.3			1	272,728.3			
<b>Дүн</b>	<b>10</b>	<b>12,684,089.1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>10</b>	<b>12,684,089.1</b>	<b>9</b>	<b>12,411,360.8</b>	<b>1</b>	<b>272,728.3</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

Бодлогоор ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бэлтгэн нийлүүлэгч компаниудаас ирүүлсэн авлага, өглөг хаах албан тоот, хүсэлтийг үндэслэн компани хоорондын тооцооны үлдэгдлийг хааж байна.	1	-			1	-				
Хамтын гэрээний дагуу ажилтнаас төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг байгууллага хариуцан төлж зардалын өсгөсөн байна.	1	375,917.1			1	375,917.1				
Тайлант оны эцсээр 3,234.8 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг баталгаажуулаагүй.	1	3,234,797.4			1	3,234,797.4				
Тайлант оны эцсээр 9,407.3 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.	1	9,407,301.3			1	9,407,301.3				
Дараа тайлан нь зохих журмын дагуу хугацаандаа хаагдахгүй байгаагаас авлага найдваргүй болох, баталгаажигдахгүй байх нөхцөл үүсч байна.	1	118,747.5			1	118,747.5				
Төрийн өмч хөрөнгийг холбогдох дээд газрын шийдвэргүйгээр Шивээ овоо ТӨХК руу шилжүүлсэн.	1	263,400.0			1	263,400.0				
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>13,400,163.3</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>6</b>	<b>13,400,163.3</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>





Багануур ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд компанийн ажилтнуудыг танхимын сургалтанд хамруулсан.	1	8,520.0			1	8,520.0		
Хамтын гэрээний дагуу төрийн дээд одон медаль хүртсэн, тэмцээн уралдаанд амжилттай оролцсон ажилтнуудтай холбоотойгоор шагнал урамшуулал, бэлэг дурсгалын зүйлсийн зарцуулалт хийгдсэн байна.	1	64,327.2			1	64,327.2		
ТУЗ-ийн гишүүдэд үр дүнгийн шагнал олгосон.	1	32,984.4	1	32,984.4				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>105,831.6</b>	<b>1</b>	<b>32,984.4</b>	<b>2</b>	<b>72,847.2</b>	<b>0</b>	<b>0</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Компани 20-100 сая төгрөгийн үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээг худалдан авахдаа харьцуулалтын аргыг ашиглалгүй 10,820.3 сая төгрөгийн 212 бэлтгэн нийлүүлэгчтэй шууд гэрээ байгуулсан.	1	10,820,318.8			1	10,820,318.8		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>10,820,318.8</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>10,820,318.8</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>10,926,150.4</b>	<b>1</b>	<b>32,984.4</b>	<b>3</b>	<b>10,893,166.0</b>	<b>0</b>	<b>0</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

20.13

03

21

363/АДИСОНЕ

СНХТ - 2023/СЗ/НА - СТА - ТВА

Утасны баар ар 401

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Нийт 158 харилцагчийн 3,234,797,375.14 (Гурван тэр бум хоёр зуун гучин дөрвөн сая долоон зуун ерэн долоон мянга гурван зуун далан таван төгрөг арван дөрвөн мөнгө) төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8 "Төрийн өмчит хуулийн этгээд нь өр авлагыг барагдуулж ажиллах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө. Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.7-д заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/, Ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч /Т.Ариунболд/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.САМБУУНЯМ

"НИЙСЛЭЛ-АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Т.СУГАРСҮРЭН

Монгол Улс, Улиастай хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Зөвсийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Хувийн шаардлага 2023/03/03/НА-СТА-ТВА

0001081202





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 21 № 524/АСБСН/6  
СНАГ-2023/СБ/НА-СТА-ТВА

Улаанбаатар, хэт

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Нийт 294 харилцагчийн 9,407,301,324.46 (есөн тэрбум дөрвөн зуун долоон сая гурван зуун нэг мянга гурван зуун хорин дөрвөн төгрөг дөчин зургаан мөнгө) төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8 "Төрийн өмчит хуулийн этгээд нь өр авлагыг барагдуулж ажиллах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө. Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.7-д заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/, Ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч /Т.Ариунболд/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
НИЙСЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Я.САМБУУНЯМ  
Т.СУГАРСҮРЭН

0001081704



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 21 № 568/А0152416  
СНМТ - АС/С/СВ/КА - СТА - ТБА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Компанийн эргэлтийн бус хөрөнгийн "бусад хөрөнгийн данс"-наас 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Шивээ овоо ХК руу 263,400,000.00 (хоёр зуун жаран гурван сая дөрвөн зуун мянга) төгрөгийн өртөг бүхий алхагч краны эд ангийг эргэн буцах нөхцөлөөр дээд шатны байгууллагын шийдвэргүйгээр, компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т "Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, Засгийн газраас зөвшөөрөл олгосон тохиолдолд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно", гэж 31 дүгээр зүйлийн 31.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно", 31.2-т "Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд хөрөнгийг худалдах, шилжүүлэхэд энэ хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авна." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө. Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.3-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн өмчийн хөрөнгийг худалдах, шилжүүлэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтуудыг баримтлан, зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/, Ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч /Т.Ариунболд/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
"НИЙСЛЭЛ-АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Я.САМБУУНЯМ  
Т.СУГАРСҮРЭН

0001081206





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 21 № 565/АДИСЦ/16  
СНАГ - 8023/СБ/НА-СТА-ТВА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Харилцагчдаас ирсэн албан бичгийг үндэслэн байгууллагуудын хооронд үүссэн авлага, өр төлбөрийн тооцоог хооронд нь шилжүүлэн бүртгэж байна.

Энэ нь Санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлалын үнэн зөв толилуулах, шалгах боломжтой байх зэрэг чанарын шинжүүд, мөн НББОУС 32-ын Санхүүгийн хэрэглүүр: Толилуулгад тусгасан Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийг харилцан суутгаж цэвэр дүн гаргах тухай Прагграф 42-той нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө. Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нотлох баримтгүй байгууллага хоорондын тооцоо, авлага өглегийг хаахгүй байх, зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/, Ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч /Т.Ариунболд/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.САМБУУНЯМ

"НИЙСЛЭЛ-АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Т.СУГАРСҮРЭН

0001081208



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 21 н: 566/АХК/116  
СНАТ - 2023/08/НА - СТБ - ТБА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд нийт 939,754,768.00 (есөн зуун гучин есөн сая долоон зуун тавин дөрвөн мянга долоон зуун жаран найм) төгрөгийн дараа тооцоог олгосноос харилцагч байгууллага, хувь хүний өргөдөл, албан бичиг хүсэлтийг үндэслэн хаасан 52,702,564.71 (тавин хоёр сая долоон зуун хоёр мянга таван зуун жаран дөрвөн мянга далан нэгэн мөнгө) төгрөг, хугацаандаа хаагдаагүй 66,044,913.90 (жаран зургаан сая дөчин дөрвөн мянга есөн зуун арван гурван төгрөг ерэн мөнгө) төгрөг, нийт 118,747,478.61 (нэг зуун арван найман сая долоон зуун дөчин долоон мянга дөрвөн зуун далан найм зууны жаран нэг) төгрөгийн зөрчил гарсан байна.

Энэ нь Компанийн мөрдөж буй "Дараа тайлангаар бэлэн мөнгө олгох, тооцоог хаах" журмын 5.1.1-д "сэлбэг бараа материал, бусад хангамжийн зүйлс худалдан авахаар бэлэн мөнгө авсан бол Улаанбаатар хот дотор худалдан авалт хийхээр бэлэн мөнгө авснаас хойш ажлын 10 хоногийн дотор, гадаад улс болон бусад аймаг орон нутагт худалдан авалт хийхээр бэлэн мөнгө олгогдсоноос хойш 10 хоногийн тайланг тушааж тооцоог хийнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Компанийн дараа тайлангаар бэлэн мөнгө олгох, тооцоог хаах журам болон кассын үйл ажиллагааны журмыг чанд мөрдөн ажиллах, зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/, Ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч /Т.Ариунболд/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

"НИЙСЛЭЛ-АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Я.САМБУУНЯМ

Т.СУГАРСҮРЭН

0001081211





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 21 № 571/АЛСДНГ  
СРБГ - 2023/СЗ/НБД - СТА - 70А

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Компани 20-100 сая төгрөгийн үнийн дүнтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа харьцуулалтын аргыг ашиглалгүй 10,820,318,842 (арван тэрбум найман зуун хорин мянга гурван зуун арван найман мянга найман зуун дөчин хоёр) төгрөгийн 212 бэлтгэн нийлүүлэгчтэй шууд гэрээ байгуулсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 "Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр босго үнийг тогтооно", Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтад "Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртөг нь бараа, үйлчилгээний хувьд дээд хязгаар нь 70 сая төгрөг, доод хязгаар нь 20 сая төгрөг, ажлын хувьд дээд хязгаар нь 100 сая, доод хязгаар нь 20 сая төгрөг байна" заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө. Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9-д заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/, Ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч /Т.Ариунболд/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
"НИЙСЛЭЛ-АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Я.САМБУУНЯМ  
Т.СУГАРСҮРЭН

0001081213



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 21 16:59 /АХК/ ИГ  
СНАТ- 2023/58/КА - СТА - ТРА

Утгаан/хатгал 477

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд Хамтын гэрээний дагуу компанийн ажилтнаас төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг байгууллага хариуцан төлж, зардлыг 375,917,148.00 (гурван зуун далан таван сая есөн зуун арван долоон мянга нэг зуун дөчин найм) төгрөгөөр өсгөсөн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1-д "Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь 2 байна" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө". Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Ажилтны эрүүл мэндийн даатгалын суутгалыг тооцохдоо Нийгмийн даатгалын тухай хуулийг мөрдөж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/, Ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч /Т.Ариунболд/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
"НИЙСЛЭЛ-АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Я.САМБУУНЯМ  
Т.СУГАРСҮРЭН

0001081218





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 21 № 527/АГЭСНГ  
СНАГ-2023/СБ/НА-СТА-ТБА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:



Тайлант хугацаанд компанийн ажилтнуудыг танхимын сургалтуудад хамруулж, 8,520,000.00 (найман сая таван зуун хорин мянга) төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т "сургалт, семинар, хурал зөвөлгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/, Ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч /Т.Ариунболд/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ  
АУДИТЫН МЕНЕЖЕР  Я.САМБУУНЯМ  
"НИЙСЛЭЛ-АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ  Т.СУГАРСҮРЭН

0001081715



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 05 дүгээр сарын 21 № 570/АД/2023  
СНАТ-2023/58/НА-СТА-74

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд төрийн дээд шагнал, одон медаль хүртсэн ажилтнууд болон ойн арга хэмжээ, тэмцээн уралдаантай холбоотой шагнал, бэлэг дурсгалд 64,327,200.00 (жаран дөрвөн сая гурван зуун хорин долоон мянга хоёр зуу) төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", 15.1.5 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/, Ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч /Т.Ариунболд/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*[Signature]*

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

*[Signature]*

Я.САМБУУНЯМ

"НИЙСЛЭЛ-АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

*[Signature]*

Т.СУГАРСҮРЭН

0001081216





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 ОУ Дугаар сарын 01 № 152/А0150/116

Улаанбаатар хот

ЦНАГ-2023/158/11А-СГА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Багануур ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Багануур ТӨХК нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд жилийн үр дүнгийн шагнал 32,984,388.00 (гучин хоёр сая есөн зуун наян дөрвөн сая гурван зуун наян найм) төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-т "хууль тогтоомжит зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал урамшуулал, дэмжлэг олгох", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.12-т "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.1-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд олгосон үр дүнгийн шагналд зарцуулсан 32,984,388.00 (Гучин хоёр сая есөн зуун наян дөрвөн мянга гурван зуун наян найман мянга) төгрөгийг Төрийн сан дахь Үндэсний аудитын газрын Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Багануур ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/, Ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч /Г.Ариунболд/ нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
"НИЙСЛЭЛ-АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Я.САМБУУНЯМ  
Т.СУГАРСҮРЭН

0001090138